

СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ ШИНЭЭР БОЛОН СУНГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХ ТУХАЙ

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1.6 , Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйл, ХХААЯамны сайдын 2004 оны 58 дугаар тушаалаар батлагдсан “Согтууруулах, ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”ын 5 дугаар хэсгийг үндэслэн Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд туршилтын үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартын мөрдөлт, лабораторийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хяналт тавин ажилладаг.

Аж ахуйн нэгж байгууллагууд нь дараахи материалуудыг бүрдүүлж ажлын хэсэгт бүрдүүлж өгдөг.

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
2. Улсын мэргэжлийн болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн ажлын байрны болон бүтээгдэхүүний эрүүл ахуйн дүгнэлт
3. Улсын бүртгэлийн гэрчилгээ
4. Татварын газрын тодорхойлолт
5. Тохирлын гэрчилгээ
6. Галын газрын дүгнэлт

Ажлын хэсэг нь дээрхи материалуудыг бүрдүүлж дүгнэлт гарган Хүнсний асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагад материалыг хүргүүлдэг.

Хүнсний асуудал эрхэлсэн төв байгууллагаас тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгах , үйл ажиллагааг зогсоох зэрэг асуудлыг шийдвэрлэдэг.